



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 78

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 131,043,904.00 /нэг зуун гучин нэгэн сая дөчин гурван мянга есөн зуун дөрвөн/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 6 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Баттогтоход дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг байгууллагадаа төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн
78 дугаар тогтоолын хавсралт

“Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Опель монтеро, 52-53 ДГА, арал № JLCOB25GN7103627	1992/ 1999	356000	25,326,000.00	25,326,000.00	0	0	500,000.00
2	Патрол, 59-01 ДГА, арал № JN1TCSY61ZO542306	2003/ 2004	432952	48,642,300.00	48,642,300.00	0	0	1,000,000.00
3	Мерседес бенз, 00-52 ДГА, арал № WDB2100351A893843	1999/ 2017	225298	3,984,770.00	3,984,770.00	0	0	1,000,000.00
4	Асфальт зүсэгч 15А, ТСС	2009/ 2009	265000	924,513.00	924,513.00	0	0	200,000.00
5	Доргиурт алх, ТР80У	2009/ 2009	21200	703,893.00	703,893.00	0	0	200,000.00
6	Исузу, 78-71 ДГО, арал № JALFTR33F37000016	2003/ 2004	146072	51,462,428.00	51,462,428.00	0	0	500,000.00
	Нийт дүн			131,043,904.00 /нэг зуун гучин нэгэн сая дөчин гурван мянга есөн зуун дөрвөн/	131,043,904.00 /нэг зуун гучин нэгэн сая дөчин гурван мянга есөн зуун дөрвөн/	0	0	3,400,000.00 /гурван сая дөрвөн зуун мянган/